



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 7/28

Улиастай

Шагнал гардуулах, бэлтгэл ажлыг хангах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 32, 43 дахь хэсэг, 2021 оны "Аймгийн шагналын журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3, 3.5, 3.6, 3.7, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, аймгийн аварга малчин өрх, аймгийн алдарт уяач, аймгийн хошой болон гоц мэргэн цол хүртсэн харваач, шилдэг сум, баг, шилдэг байгууллага, салбарын тэргүүний ажилтан, оны онцлох иргэний шагнал, урамшууллыг Улаанбаатар хотод болон сумдад бэлтгэх, бэлтгэл ажлыг хангах, шагнал гардуулах үйл ажиллагааг чанартай зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Мягмарсүрэн)-т үүрэг болгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (У.Батдаваа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Г.ОЧОРБАЯР



d/zahiramj.doc

810901-118